

## ЭРДЭНЭ РЕСУРС ЗҮҮН-ӨМНӨД УЛААН ТАЛБАЙД 68.2 Г/Т АЛТНЫ АГУУЛГА БҮХИЙ 3 МЕТР БАГТААСАН 8.1 Г/Т АЛТНЫ АГУУЛГА БҮХИЙ 41 МЕТРИЙН ИНТЕРВАЛ ОГТОЛЛОО

---

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот  
2022.06.06

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Монгол Улсын баруун өмнөд бүс дэх Баян Хөндий алтны төслөөс баруун зүгт 300 метрт орших Зүүн Өмнөд Улаан талбайн 2022 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн эхний шатны үр дүнг танилцуулахад таатай байна. Энэхүү хөтөлбөрийн зорилт нь Зүүн Өмнөд Улаан нээлтийн хойд хэсэгт байрлах өндөр агуулга бүхий алт агуулагч “тэжээгч” структур тасралтгүй оршиж буйг баталгаажуулах болон баруун зүгт болон гүндээ тэлэх боломжийг тодорхойлоход оршиж байв.

### Онцлох мэдээлэл

- Зүүн Өмнөд Улаан талбайн хойд хэсэгт “тэжээгч” структурын төсөөллийг туршсан бөгөөд Улаан талбайд өнөөг хүртэл хамгийн өндөр агуулга бүхий интервал огтоллоо
  - 68.3 г/т алтны агуулга бүхий 3 метр агуулсан 8.1 г/т алтны агуулга бүхий 41 метр интервал (UDH-35), түүнээс Улаан талбайд огтолсон хамгийн өндөр мөнгөний агуулга болох 133 г/т мөнгөний агуулга бүхий 1 метр интервал огтолсон
  - Баруун доош сунаж өрөмдсөн цооногийн (UDH-53) кварц судал, брекчийн хүчтэй хувирлын бүсэд нүдэнд үзэгдэх алт илэрсэн
  - Боломжит “тэжээгч” бүс нь баруун зүгт болон гүндээ нээлттэй байна
- “Тэжээгч” бүсийн өмнөд хэсэгт UDH-36 цооногоор Зүүн-Өмнөд Улаан нээлтийн хэд хэдэн цооногт тогтоогдсон зузаан алтны хүдэржсэн бүс үргэлжилж байгааг тодорхойлсон.
  - Кварц адулярийн судал болон штокверкд 33.4, 15.5, 14.4 ба 10.8 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 1.2 г/т алтны агуулга бүхий 179 метрийн интервал нь хүдэржилтээр төгссөн.
- UDH-35 цооногоос баруун зүгт 150 метрийн зайд байрлах UDH-28 цооногоор туф агуулагчийн доош сунасан төсөөллийг шалгасан.

- Бага агуулга бүхий алтны хүдэржилтийн зузаан интервалууд огтолж, хүдэржсэн бүс баруун зүгт тэлж байгааг баталгаажуулсан ба баруун зүгтээ нээлттэй.
- UDH-21 цооногийн өргөтгөлөөр Зүүн-Өмнөд Улаан талбайн гүнийг судалсан
  - Өмнө танилцуулснаар 3.2 г/т алтны агуулга бүхий 77 метрт 8.7 г/т алтны агуулга бүхий 27 метрийн интервал багтаж байсан нь хүдэржилтээр төгссөн ([Хэвлэлийн мэдээтэй танилцана уу](#))
  - Өрөмдлөгөөр 0.5 г/т алтны агуулга бүхий 108 метр огтолсон нь 0.9 г/т алтны агуулга бүхий 33 метрээр төгссөн
- Хоёр цооногоор (UDH-37 ба UDH-38) хүдэржилтийн өмнөд болон баруун өмнөд хэсгийг шалгасан нь алтны хүдэржилт тасралтгүй үргэлжилж байгааг баталгаажууллаа.
- Баян Хөндийн урвуу эргэлтэт (“Reverse Circulation”) өрмийн хөтөлбөрийг одоогоор гүйцэтгэж байна
  - Хөтөлбөр нь Хар Морийн Дэл талбайтай төстэй өндөр агуулга бүхий газрын дөт гүнд исэлдсэн хүдэржилтийг шалгах зорилготой. (үүнд 123 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал багтаж байна [Хэвлэлийн мэдээтэй танилцана уу](#))
  - Нийт 179 гүехэн цооногийн өрөмдлөг гүйцэтгэсэн (1,314 метр) – үр дүнг 2022 оны 3-р улиралд танилцуулна.

## Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Улаан тусгай зөвшөөрлийн талбайд өнөөг хүртэл илрүүлсэн хамгийн өндөр дундаж агуулга бүхий интервалууд бүхий өнөөдрийн үр дүнгүүд, мөн баруун зүг болон гүндээ тэлэх боломжууд нь энэхүү шинэ нээлтийн цар хүрээг харуулж байна. Хүдэржилт нь судлын дагуу 200 метр тэлж, 400 метрийн гүн хүртэл үргэлжилж байгаа нь баруун зүг болон гүндээ нээлттэй хэвээр байна.”

“Энэхүү Зүүн-Өмнөд Улаан талбайн амжилттай үр дүнгүүд нь Хөндий Дүүрэгт олон сая унц алтны нөөцийг тодорхойлох боломжтой гэсэн бидний итгэлийг бататгаж байна. Бид Хөндий Дүүрэгт газрын гадаргаас 100 метрт өндөр агуулга бүхий алтны хүдэржсэн таван бүсийг тодорхойлсон. Эдгээр бүсүүдэд өндөр агуулга бүхий структурыг тойрон бага агуулга бүхий зузаан интервалууд (100 метрээс дээш) оршиж байгаа нь илээр олборлох боломжтой их нөөцтэй ордын боломжуудыг харуулж байна. Бид хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон ба 3-р улиралд үргэлжлүүлэн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Бид 2022 он болон ирээдүйд нөөцийг үргэлжлүүлэн тэлэх, шинэ нээлтүүд хийх зорилтын хүрээнд ажиллаж байна.”

## Өрөмдлөгийн үр дүнгийн хураангуй

Зүүн-Өмнөд Улаан талбайн өрөмдлөгийн хөтөлбөрийн үндсэн зорилго нь Зүүн-Өмнөд Улаан нээлтийн хойд зүгт структурын огтлолцлын дагуух өндөр агуулга бүхий “тэжээгч” бүсүүдийг турших юм. Түүнээс гадна, нээлтийн тэлэлтийн боломжийг шалгахар өмнөд, баруун зүг болон гүн рүү судалгаа хийв.

Зүүн-Өмнөд Улаан өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд нийт 2,463.7 тууш метр зургаан цооног болон таван цооногийн өргөтгөл өрөмдсөн. Энэхүү хэвлэлийн мэдээнд зургаан шинэ цооногийн дөрөв, таван цооногийн өргөтгөлийн үр дүнгүүдийг багтаасан. Хүснэгт 1-т үр дүнгүүдийн хураангуйг харуулав. Зүүн-Өмнөд Улаан өрөмдлөгийн хөтөлбөрийн хоёр цооногийн (UDH-52 ба UDH-53) үр дүн хүлээгдэж байна.

Энэхүү хөтөлбөрөөр өндөр агуулга бүхий хүдэржилтийн бүсийг тодорхойлсон нь структуруудын огтлолтой холбоотой ба тэжээгч бүс байх боломжтойг харууллаа. UDH-35 цооногт Зүүн-Өмнөд Улаан талбайн өнөөг хүртэл илрүүлсэн хамгийн өндөр агуулга буюу цооногийн 187 метр гүнээс эхлэн 8.1 г/т алтны агуулга бүхий 41 метр интервал огтолсон. UDH-35 цооногт мөнгөний өндөр агуулга (үүнд цооногийн 203 метрээс эхлэн дунджаар 30 г/т мөнгөний агуулга бүхий 8 метр) илрүүлсэн нь структур нь шингэн эх үүсвэрт ойр буйг дэмжих үзүүлэлт болж байна.

UDH-35 цооногоос баруун урд зүгт 30 метрийн зайд UDH-36 цооног өрөмдсөн нь Зүүн-Өмнөд Улаан нээлтийн олон цооногт илэрсэн зузаан алтны хүдэржсэн бүс үргэлжилж байгааг баталгаажуулсан. Тус цооногийн онцлох үр дүнгүүдэд кварц адулярийн судал болон штокверкд 1.2 г/т алтны агуулга бүхий 179 метр интервал нь хүдэржилтээр төгссөн ба үүнд 33.4 г/т, 15.5 г/т, 14.4 г/т, 10.8 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервалууд багтсан.

Хайгуулын цооног болон өргөтгөлийн цооногууд нь баруун зүгт болон гүндээ нээлттэй хэвээр байгаа нь мэдэгдэж буй хүдэржилтийн бүсийг тэлсээр байна. UDH-37 өрөмдлөгийн цооног нь алтны хүдэржсэн туф агуулагч литологийг огтолж, хайгуулын хөтөлбөрийг үргэлжлүүлэн баруун өмнө зүгт гүйцэтгэхэд алтны хүдэржилт тэлэх боломжийг нэмэгдүүлсэн. UDH-38 цооногоор UDH-37 цооногийн амжилттай үр дүнг үргэлжлүүлэн, баруун зүгт алтны хүдэржилтийг тэлсэн. Гэхдээ алтны хүдэржилт илүү гүехэн буюу цооногоос 42 метрийн гүнээс эхэлж байна.

UDH-35 цооногоос баруун зүгт 150 метрийн зайд орших UDH-28 цооногийг литологи агуулагчийн доош сунасан төсөөллийг туршихаар өрөмдсөн. Цооногоор бага агуулга бүхий алтны хүдэржилтийн зузаан интервал огтолж, хүдэржсэн бүс баруун зүгт үргэлжилж байгааг баталгаажуулсан нь баруун зүгт нээлттэй байна.

Цооногийн өргөтгөлөөр (100-200 метр, гүн рүү 350-450 метр) алтны хүдэржилт нь >400 м-ээс дээш хувирсан болон цахиуржсан галт уулын босоо зузаан үеүүдэд үргэлжилж байгааг тодорхойлсон. Хүдэржилт нь гүндээ нээлттэй бөгөөд хоёр цооног 450 метр хүртэл үргэлжлэн, хүдэржилтээр төгссөн.

## Хүснэгт 1: 2022 оны 2-р улирлын Улаан талбайн өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох мэдээлэл

(Дунджаар 0.30 г/т алтны агуулгаас дээш интервалуудыг танилцуулав)

Цооног	М-ээс	М хүртэл	Интервал <sup>(1)</sup>	г/т алт
<b>Шинээр өрөмдсөн цооногууд</b>				
UDH-35	107	116	9	0.49
Ба	176	178	2	0.46
Ба	187	228	41	8.10
Үүнд	188	211	23	13.73
Үүнд	188	189	1	10.87
Үүнд	197	198	1	44.40
Үүнд	208	211	3	68.32
Үүнд	208	209	1	108.12
Ба	235	238	3	0.36
Ба	246	251 <sup>(2)</sup>	5	0.34
UDH-36	2	4	2	0.51
Ба	72	251 <sup>(2)</sup>	179	1.23
Үүнд	106	107	1	15.52
Үүнд	142	143	1	14.36
Үүнд	146	147	1	10.84
Үүнд	227	228	1	33.43
UDH-37	64	68	4	0.44
Ба	168	272	104	0.31
Үүнд	202	246	44	0.51
UDH-38	42	68	26	0.30
Ба	193	262	69	0.48
Ба	346	348	2	0.56
<b>Цооногийн өргөтгөл</b>				
UDH-08	20	22	2	0.44 <sup>(3)</sup>
Ба	202	206	4	0.37
UDH-12	310	314	4	0.36
Ба	324	328	4	0.46
Ба	338	340	2	0.58
UDH-17	287	289	2	1.71 <sup>(3)</sup>
Ба	314	368	54	1.55 <sup>(4)</sup>
Үүнд	348	350.3	2.3	21.57 <sup>(3)</sup>
Ба	412	422	10	0.33
Ба	425	426	1	0.39
Ба	432	434	2	0.30

Цооног	М-ээс	М хүртэл	Интервал <sup>(1)</sup>	г/т алт
UDH-21	115	192	77	3.19 <sup>(3)</sup>
Үүнд	131	158	27	8.74 <sup>(3)</sup>
Үүнд	139	140	1	156.54 <sup>(3)</sup>
Үүнд	155	156	1	20.98 <sup>(3)</sup>
Ба	209	280	71	0.81 <sup>(3)</sup>
Үүнд	257	271	14	2.79 <sup>(3)</sup>
Ба	304	318	14	0.34 <sup>(3)</sup>
Ба	342	450.3 <sup>(2)</sup>	108.3	0.53 <sup>(4)</sup>
Үүнд	417	450.3 <sup>(2)</sup>	33.3	0.91
Үүнд	417	420	3	2.31
UDH-28	282	291	9	0.47 <sup>(3)</sup>
Ба	306	356	50	0.47 <sup>(4)</sup>
Ба	370	384	14	0.37
Ба	394	450 <sup>(2)</sup>	56	0.34

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой
2. Цооногийн төгсгөл
3. Өмнө мэдээлэлж байсан цооног
4. Цооногийн өргөтгөл

Зүүн-Өмнөд Улаан нээлтийн баруун, Улаан тусгай зөвшөөрлийн талбайн өмнө болон баруун зүгт хэтийн төлөв өндөр хэд хэдэн талбайд хайгуулын өрөмдлөг гүйцэтгэсэн. Нийт 1,441.6 тууш метрийн 13 хайгуулын, 1 цооногийн өргөтгөлийн өрөмдлөг гүйцэтгэсэн бөгөөд үр дүн хүлээгдэж байна.

### Ирээдүйн төлөвлөгөө

Зүүн-Өмнөд Улаан талбайн амжилттай үр дүнгүүд үргэлжилсээр байгаа нь энэхүү алт агуулсан системийг тодорхойлж, эрдэсжилтийг тэлэх бидний зорилт, хүчин чармайлтыг нэмэгдүүлж байна. Улаан талбайг баруун зүгт тэлэх болон бидний тодорхойлж буй “Тэжээгч бүс”-ийг тэлэх өргөн хүрээтэй хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Одоогоор энэхүү хөтөлбөрийг боловсруулж байгаа бөгөөд хүлээгдэж буй үр дүнгүүдийг танилцуулах үед мэдээлэх болно. Улаан талбайн өрмийн хөтөлбөрийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ ирэх саруудад Хар Морь, Алтан Сум, Алтан Нар талбайд нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэнэ. Энэ хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 2022 оны 3-р улиралд танилцуулна.

Өмнө нь танилцуулсан 3,000 метрийн урвуу эргэлтэт (Reverse Circulation) өрөмдлөгийн хөтөлбөр одоо хэрэгжиж байгаа бөгөөд 180 орчим цооног өрөмдсөн. RC хөтөлбөрийн зорилго нь 2021 онд Хар Морийн Дэл талбайд (195 г/т алтны агуулга бүхий 1 метр) огтолсонтой адил залуу тунамлаар бүрхэгдсэн гүехэн, исэлдэлт суперген алтны бүсийг туршихад оршино. Энэхүү хөтөлбөрт гүехэн (ойролцоогоор 10-15 метр гүн) RC өрөмдлөгийн цооногуудыг багтаасан бөгөөд энэ нь алмазан өрөмдлөгтэй харьцуулахад илүү хурдан бөгөөд харьцангуй бага зардалтай. Хөндий болон Улаан тусгай зөвшөөрлийн талбай, Хар Морь зэрэг хэд хэдэн талбайд RC өрөмдлөгийн бүсүүдийг тодорхойлсон.

Алт агуулсан исэлдсэн бүсүүд нь Хөндий Алтны Дүүргийн элэгдэлтийн түвшин, гидрогеологи болон агаар мандлын нөхцөл зэрэг гүн исэлдэлт болон алтны хүдэржилтийг супергенээр баяжуулах таатай нөхцөл бүрдүүлснийг илэрхийлдэг. Энэ нь Хөндий дүүрэгт газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий алтны хүдэржилтийн нэмэлт нээлт хийх боломжтойг харууллаа.

### Зүүн-Өмнөд Улаан нээлтийн тухай

Зүүн-Өмнөд Улаан нээлтийг 2021 оны 3-р улиралд гадаргын эрдэсжилтгүй нөхцөлд нээн илрүүлсэн. [\(Улаан талбайн 2-р улирлын видеотой танилцана уу\)](#)

Нээлт нь 200м\*250 метрийн талбайг хамарсан 400 метр хүртэл зузаан алтны хүдэржилтээр тодорхойлогддог. Алтны хүдэржилт нь 80 метрийн гүнээс эхэлдэг, баруун-баруун хойд зүгт судлын дагуу болон гүндээ нээлттэй. Үүнд UDH-22 (85 метрээс) цооногт 1.7 г/т алтны агуулга бүхий 152 метр, UDH-21 (115 метрээс) 3.2 г/т алтны агуулга бүхий 77 метрийн интервалууд огтолсон.

Талбайн зүүн талд 300 метрт орших Баян Хөндий алтны ордын шинж чанартай ижил, маш өндөр агуулга бүхий кварц ± гематит, адулярын судал болон цагаан гялтгануурын хувиралтай лапилли туфтай ижил зузаалагт агуулагдаж буй штокверк бүсээр тодорхойлогддог.

Улаан тусгай зөвшөөрлийн талбайн өмнөд хэсэгт 3.5км\*1км талбайд аномаль хөрсний алт бүхий бүсүүд байдаг. Суурь геологи, хувирлаас харахад Зүүн Өмнөд Улаан, Баян Хөндийн алтны хүдэржилт нь цагаан гялтгануур болон цахиурын хувирал бүхий туфын нэгжүүдтэй төстэй. Энэхүү өндөр хэтийн төлөв бүхий талбайг шалгахар хэд хэдэн цооног өрөмдсөн бөгөөд үр дүнгүүд хүлээгдэж байна.

### Хөндий алтны дүүрэг

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Транс Алтайн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. 2021 онд компани нь Хар морь, Зүүн-Өмнөд Улаан гэсэн хоёр томоохон шинэ алтны хэтийн төлөвийг тодорхойлсон.

Баян Хөндийд 2.19 г/т дундаж алтны агуулга бүхий 585,100 унц баттай болон бодитой геологийн нөөц<sup>1</sup> (“Measured and Indicated Resources”)<sup>2</sup>, 2.18 г/т алтны агуулга бүхий 35,900 унц боломжит нөөц (“Inferred Resources”)<sup>3</sup> тодорхойлогдсон.

<sup>1</sup>Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2021 оны 8 сарын 16-нд танилцуулсан 2021 оны 2-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангийн хэвлэлийн мэдээнээс танилцана уу.

<sup>2</sup>Баттай & Бодитой геологийн нөөц: 2.39 г/т алтны агуулга бүхий 232,700 унц баттай, 2.08 г/т алтны агуулга бүхий 352,400 унц бодитой нөөц

<sup>3</sup>Батлагдсан & Магадласан: 4.4. г/т алтны агуулга бүхий 165,000 унц батлагдсан, 3.4 г/т алтны агуулга бүхий 256,000 унц магадласан үйлдвэрлэлийн нөөц; Үйлдвэрлэлийн нөөцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хөндий Алтны Төсөл NI 43-101 Техникийн Тайлан, Tetra Tech 2019 оны 12 сарын 4-нд SEDAR болон компанийн вебсайт дээрх мэдээлэлтэй танилцана уу

Баттай болон Бодитой нөөцөд 3.7 г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. [\(Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу\)](#) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

## Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуулын 1, ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com) -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

## Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмит спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь

2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Тайлагнасан интервал нь бодит зузаан бөгөөд өөрөөр хэлбэл цооногийн өргөн юм. Улаан талбайн өрөмдлөгийн цооногуудыг 85 градусын уналаар өрөмдсөн ба алт агуулсан судлын баруун-хойд баруун трендийн дагуу баруун урд уналын дагуу чиглэсэн. Бодит өргөнийг баталгаажуулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Интервалуудын тайлагнасан агуулга нь түүвэр интервалын уртад үндэслэсэн жигнэсэн дундаж үзүүлэлтүүд юм. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т болон 100 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

### Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>


Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>



# KHUNDII MINERALS DISTRICT – MULTI-MILLION OUNCE POTENTIAL



## Four Gold Discoveries, Molybdenum Copper Deposit & Multiple High-Priority Targets



# A SETTING FOR WORLD CLASS GOLD AND COPPER DEPOSITS



## The Bayan Khundii Ulaan Hydrothermal Alteration Complex

0 500 1000 1500 Azimuth 093



# ULAAN SOUTHEAST GOLD DISCOVERY: Q2 2022 DRILLING DEFINES HIGH-GRADE STRUCTURE

## UDH-35 intersects 8 g/t gold over 41 metres, including 68 g/t gold over 3 metres



# HIGH-GRADE STRUCTURE – INTERPRETED FEEDER ZONE

UDH-35 Core Photos – 3 metres averaging 68 g/t gold

208.7m

10cm sugary comb quartz-white mica vein, abundant VG

210.3m

10cm sugary comb quartz & white mica matrix breccia, trace VG

209.4m

10cm sugary comb quartz-white mica vein, abundant fine VG

209.6m

Lapilli tuff host intense silica-adularia-white mica altered cut by quartz-white mica stringer veins with VG

210.9m

Sugary comb quartz-white mica vein with abundant VG cut by white mica matrixed